

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР АШИГЛАН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ

1. Доорх даалгавар алв түвшинд хамаарах вэ?

Ногооны агуулах бүх ногооныхоо $\frac{2}{5}$ -ыг ба үлдсэн ногооны $\frac{1}{3}$ -ийг худалдахад 120 кг ногоо үлдэв. Агуулахад анх хэдэн килограмм ногоо байсан бэ?

Бодлогоо хавтан эсвэл хэрчмээр зураглал хийж бодоорой.

A. Сонгох B. Задгай C. Холимог D. Нарийвчлалтай

2. Дараах **63 857 040** тоонд **7** гэсэн цифр ямар оронг илэрхийлж байна вэ?

A. зуут B. мянгат C. Аравт D. арван мянгат гэсэн даалгавар танин мэдэхүйн аль түвшинд орох вэ?

A. Сэргээн санах B. Ойлгох C. Хэрэглээ D. Үнэлэх

3. Үнэлгээ гэсэн ойлголтыг хамгийн оновчтой тодорхойлсон хариултыг сонгоно уу.

A. Багшийн сурагчдын тавьж буй дүнгийг үзүүлэлт
B. Багш ээлжит хичээлээ хэрхэн сайн зааснаа үнэлж буй үзүүлэлт
C. Эзэмшсэн мэдлэг чадварыг илрүүлж буй үзүүлэлт
D. Даалгаврыг шалгаж үнэлгээ өгөх үзүүлэлт

4. Суралцахуйн үр дүнгийн шалгуурыг ямар түвшинд эзэмшсэнийг тодорхойлох илрэхийлэл..... гэж үзнэ.

A. Гүйцэтгэлийн түвшин
B. Суралцахуйн үр дүнгийн шалгуур
C. Суралцахуйн үр дүн
D. Үнэлгээний нэгж

5. Гүйцэтгэлийн хүрэх V-VI түвшинд сурагчид ямар чадвар эзэмшсэн байх шаардлагатай гэж үздэг вэ?

A. Мэдлэгээ ойлгох B. Мэдлэгэ хэрэглээ болгох
C. Анализ, дүгнэл хийх D. Тайлбарлаж, мэдлэг бүтээх